



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

「 Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэгийн  
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эцэг эхчүүдээс хандивласан нийт 5,914,000.00 (таван сая есөн зуун арван дөрвөн мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг (Б.Нэргүй)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг (Б.Нэргүй)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн АИУ, дугаар тушаалын хавсралт

Бүртгэх эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Гал тогооны шүүгээ	ДСП	4 хаалгатай	2025	сайн	ш	1	700,000.00	700,000.00	Эцэг эхчүүд Хандив
2	Гал тогооны стек	ДСП	4 хаалгатай	2025	сайн	ш	1	500,000.00	500,000.00	
3	Гал тогооны шүүгээ	ДСП	4 хаалгатай	2025	сайн	ш	1	750,000.00	750,000.00	
4	Гал тогооны стек	ДСП	4 хаалгатай	2025	сайн	ш	1	510,000.00	510,000.00	
5	Гал тогооны шүүгээ	ДСП	4 хаалгатай	2025	сайн	ш	1	600,000.00	600,000.00	
6	Гал тогооны ханын стек	ДСП	4 хаалгатай	2025	сайн	ш	1	400,000.00	400,000.00	
7	Гал тогооны шүүгээ	ДСП	6 хаалгатай	2025	сайн	ш	1	1,000,000.00	1,000,000.00	
8	Гал тогооны стек	ДСП	6 хаалгатай	2025	сайн	ш	1	794,000.00	794,000.00	
9	Алчуурын өлгүүр	ДСП	9 таславчтай	2025	сайн	ш	3	220,000.00	660,000.00	
<b>Тавилга, эд хогшлийн дүн</b>								<b>5,914,000.00</b>		